



ACCOUNTANTS &
BUSINESS ADVISORS

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

АУДИТОРЫН ТАЙЛАН

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК –ИЙН

2019 ОНЫ 12 САРЫН 31 –НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН
ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН

АГУУЛГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	i
ТАЙЛАГНАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ	1
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	3
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	3
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	4
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	5
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	6
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ	8
1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭЖ, ТАЙЛАГНАСАН ҮНДЭСЛЭЛ	7
2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ТООЦООЛЛУУД	8
3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ	9
4. ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14
5. ДАНСНЫ ӨГЛӨГ	14
6. ЭЗДИЙН ӨМЧ	14
7. ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН (АЛДАГДАЛ)	15
8. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	15
9. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА	15

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

УБ Платинум төв - 606 тоот
Энхтайваны өргөн чөлөө - 92, 2 –р хороолол-3 16081,
4 –р хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот

Утас/Факс : 976-70186131, E-mail : cooperation@pkf.mn

№ _____

танай _____ -ны № _____ -Т

**"ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС" ХК –ИЙН
ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид "Хар хорум пропертийс" ХК –ийн 2019 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2019 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ТАЙЛАГНАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД :	“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК
ХАЯГ :	ПИЙС ТАУЭР - 1306 тоот, Чингэлтэй дүүрэг, 3 –р хороо, 54 –р байр Энхтайваны өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО :	1996 оны 4 дүгээр сарын 20
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР :	9010001131
РЕГИСТРИЙН ДУГААР :	2015358
ӨМЧИЙН ХЭЛБЭР :	Хувьцаат компани
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ :	<ul style="list-style-type: none"> • 6810 Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх, Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах, Үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авахад зуучлах, Үл хөдлөх хөрөнгө түрээслэх. • 6630 Үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх
ЗАРЛАСАН ЭНГИЙН ХУВЬЦАА :	Нэг бүр нь 100 ₮ -ийн нэрлэсэн үнэ бүхий нийт 2,000,000,000 ширхэг энгийн хувьцаа.
ГАРГАСАН ЭНГИЙН ХУВЬЦАА :	Нэг бүр нь 100 ₮ -ийн нэрлэсэн үнэ бүхий нийт 36,195 ширхэг энгийн хувьцаа.

2019 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн
санхүүгийн тайланг бэлтгэх болон батлах талаарх

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Тус тайлангийн эхэнд тусгагдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах энэхүү мэдэгдэл нь “Хар хорум пропертийс” ХК –ийн 2019 оны 12 дугаар сарын 31 өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлагыг болон аудиторын хариуцлагын ялгааг тодорхойлоход чиглэгдсэн болно.

“Хар хорум пропертийс” ХК –ийн удирдлага бид санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) –ын дагуу үнэн зөв бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй бөгөөд бидний бэлтгэсэн “Хар хорум пропертийс” ХК -ийн 2019 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт нь СТОУС –ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлэгдсэн болно.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ үүгээр баталж байна.

“Хар хорум пропертийс” ХК –ийн 2019 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг нийтэд толилуулахыг зөвшөөрч батлав.

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК –ИЙН :

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: _____ :

.....

Д.ЭНХБААТАР

Огноо :

Улаанбаатар хот, Монгол улс

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 сарын 31 –ний өдрөөрх

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	(төгрөгөөр)	
		2019/01/01 –ний үлдэгдэл	2019/12/31 –ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	4	45,300.00	45,300.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		45,300.00	45,300.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		45,300.00	45,300.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	5	7,704,885.40	10,804,885.40
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		7,704,885.40	10,804,885.40
ЭЗДИЙН ӨМЧ			
Өмч :			
- Төрийн		0.00	0.00
- Хувийн		0.00	0.00
- Хувьцаат	6	3,619,500.00	3,619,500.00
Хуримтлагдсан ашиг	7	(11,279,085.40)	(14,379,085.40)
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		(7,659,585.40)	(10,759,585.40)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		45,300.00	45,300.00

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	(төгрөгөөр)	
		2018 онд	2019 онд
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)		0.00	0.00
Борлуулалтын өртөг		0.00	0.00
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)		0.00	0.00
Ерөнхий ба удирдлагын зардал	8	0.00	3,100,000.00
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)		0.00	(3,100,000.00)
Орлогын татварын зардал		0.00	0.00
ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)		0.00	(3,100,000.00)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)			
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)		0.00	(3,100,000.00)
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		0.00	0.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
Бусад олз (гарз)			0.00
ОРЛОГЫН НИЙТ ДҮН		0.00	(3,100,000.00)
НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)			

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018/01/01 –ний үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(11,279,085.40)	(7,659,585.40)
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.00
Залруулсан үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(11,279,085.40)	(7,659,585.40)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							0.00
Бусад дэлгэрэнгүй орлого							0.00
Өмчид гарсан өөрчлөлт							0.00
Зарласан ногдол ашиг							0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							0.00
2019/01/01 –ний үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(11,279,085.40)	(7,659,585.40)
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.00
Залруулсан үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(11,279,085.40)	(7,659,585.40)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						(3,100,000.00)	(3,100,000.00)
Бусад дэлгэрэнгүй орлого							0.00
Өмчид гарсан өөрчлөлт							0.00
Зарласан ногдол ашиг							0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							0.00
2019/12/31 –ний үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(14,379,085.40)	(10,759,585.40)

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	(төгрөгөөр)	
	2018 онд	2019 онд
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

Эдгээр тэмдэглэлүүд нь энэ тайлан дахь санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг бөгөөд тэдгээр тайлантай хамт уншигдана.

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭЖ, ТАЙЛАГНАСАН ҮНДЭСЛЭЛ

а) Даган мөрдөлтийн мэдэгдэл

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (НББОУСХ) –оос баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон тус зөвлөлийн тайлангийн хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн.

б) Хэмжилтийн үндэслэл

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр хэмжигдсэн төлбөрийн системийн бүртгэлийн цахим программ хангамж болон цахим бүртгэлийн системийн мэдээлэл боловсруулах компьютер, серверийн тоног тоног төхөөрөмжүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

в) Үндсэн ба тайлагнагч валют

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлсэн ба тус тайланд төгрөгөөр /мөнгөний оронг хураан харуулж/ тайлагнасан .

г) Нягтлан бодох бүртгэлийн томоохон тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС –ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх үнэлгээ, таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийгдсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

д) Өөдрөг төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ТООЦООЛЛУУД

Бодит үнэ цэнийн хэмжилт :

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө ба өр төлбөр нь бодит үнэ цэнийн хэмжилт ба тодруулгыг шаарддаг.

Аж ахуйн нэгжийн санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжихэд шаардагдах мэдээллүүд хангалттай олдоцтой үед үнэлгээний арга техник хэрэглэх нь тохиромжтой байдаг бөгөөд ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдах өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, санхүүгийн тайланд тусгагдах хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжиж, тодруулахад дараах түвшний ажиллагаа хийгддэг:

- Түвшин 1: Ижил төстэй зүйлсийн идэвхитэй зах зээл буюу бирж дээр зарлагдсан үнэ (*тохируулаагүй*),
- Түвшин 2: Түвшин 1–д зааснаас өөр ажиглагдахуйц шууд ба шууд бус өгөгдөл,
- Түвшин 3: Үл ажиглагдах өгөгдөл (*биржийн тоо мэдээнээс үүсээгүй*).

Дээрх түвшнүүдэд орох зүйлсийн ангилал нь тухайн зүйлсийн бодит үнэ цэнийн хэмжилтэнд томоохон нөлөө үзүүлж ашиглагддаг хамгийн бага түвшний өгөгдөлд суурилан ангилагддаг.

Тайлант хугацаа бүрийн эцэст компани нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө ба өр төлбөрийн түвшин бүрийн хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталдаг.

Компанийн бодит үнэ цэнээр хэмждэг зүйлс нь:

- Дахин үнэлэгдсэн бусад санхүүгийн хөрөнгө
- Биет бус хөрөнгө, хөдлөх хөрөнгө байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

Тус компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн дараах үндсэн бодлогуудыг баримталдаг.

а) Гадаад валютаарх ажил гүйлгээ

Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тайлагнах валют (төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, тайлант жилд гадаад валютаар хийгдсэн орлого, зарлагын ажил гүйлгээг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тус тус хөрвүүлсэн. (Жич: *Албан ханш гэдэг нь тухайн өдөр Монгол банкнаас зарласан хаалтын ханш болно.*)

Дээрх хугацаанд гадаад валютаар ажил гүйлгээ гараагүй байна.

б) Өмч, барилга, тоног төхөөрөмж

1. Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд цэвэр дүнгээр орлогын тайланд “бусад олз/гарз” -аар хүлээн зөвшөөрдөг.

2. Дараа үеийн зардал

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардалд гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

3. Элэгдэл

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана. Өмч, барилга, тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

- | | |
|--|--------|
| • Оффисын тавилга, тоног төхөөрөмж | 10 жил |
| • Компьютерийн дагалдах хэрэгсэл | 3 жил |
| • Программ хангамж хүчинтэй хугацаанд нь | |

Элэгдүүлэлтийн арга, ашиглах хугацаа, үлдэх өртгийг тайлагнах үе бүрт дахин тооцож үзнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

в) Түрээсэлсэн хөрөнгө

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгээр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа тохиолдолд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Ийм тодорхойлолтыг хэлцлийн шинж байдлыг үнэлсний үндсэн дээр хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийн хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

Компанийн түрээсэлж буй хөрөнгийн ангилал

- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх нөхцөлтэйгээр түрээсээр эзэмшиж буй хөрөнгө гэж ангилдаг.
- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх нөхцөлгүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг.

Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой холбогдсон бүх эрсдэл болон урамшууллыг компанид бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээслэсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түрээслэсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг. Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжиж ирэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

1. Үйл ажиллагааны түрээс

Компани нь үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмших хөрөнгө ашиглаж буй тохиолдолд түрээсийн дагуу хийгдсэн төлбөрүүд нь түрээсийн хугацаанд хамрагдах тайлант үеүдэд тэнцүү хэмжээгээр орлого зардлаар тайлагнагддаг. Хүлээн авсан түрээсийн урамшууллыг түрээсийн цэвэр төлбөрийн нийт дүнгийн нэг хэсэг болгон орлого ба зардлаар хүлээн зөвшөөрдөг. Болзошгүй түрээсийг гаргасан тухайн тайлант хугацаанд нь орлого ба зардлаар хүлээн зөвшөөрдөг.

г) Бараа материал

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана. Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлох бөгөөд худалдан авалт, боловсруулалт, байршуулалт зэрэг тухайн байршил, нөхцөлд авчрах хүртэлх зардлыг өртөгт шингээнэ.

Бараа материалыг өртөг, цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Цэвэр боломжит үнийг бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасч тооцно.

д) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

е) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө (барьцаалсан хадгаламжийг оруулахгүй)-өөс бүрдэнэ.

ё) Санхүүгийн хэрэгсэл

1. Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

СТОУС 9-д зааснаар санхүүгийн хэрэгслийг ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэл, бусад дэлгэрэнгүй орлого болох бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгсэл болон хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр гэж ангилдаг. Бүх санхүүгийн хэрэгслийг анх бодит үнэ цэнээр нь хэмжиж, хүлээн зөвшөөрдөг. Компанийн санхүүгийн хөрөнгө нь мөнгө, худалдааны ба бусад авлага, борлуулахад бэлэн үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг агуулна. Компанийн санхүүгийн өр төлбөр нь худалдааны болон бусад өглөг, банкны овердрафт, зээл, санхүүгийн баталгаат гэрээ болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг агуулна.

2. Санхүүгийн хэрэгслийн дараа үеийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Урт хугацаат санхүүгийн хэрэгсэлд тогтмол буюу тодорхойлогдох боломжтой төлбөр бүхий үүсмэл бус санхүүгийн хэрэгслүүд багтах бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш үр ашигт хүүгийн түвшний аргаар тооцсон хорогдуулсан өртгөөс үнийн бууралтыг хассан дүнгээр хэмжиж, хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хэрэгслийн хөнгөлөлт ба урамшууллыг тооцох замаар хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн аргаар тооцоолдог. Үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдуулалтыг орлогын тайланд санхүүгийн орлого ба зардлаар тайлагнадаг. Үнийн бууралтаас үүдэлтэй олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

ж) Үнийн бууралт

Үнийн бууралтыг илэрхийлсэн ямарваа нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд бараа материал, хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад хөрөнгийн дансны үнийг тайлант үеийн эцэс бүрт шалгадаг. Үнийн бууралтыг ямар нэг шинж тэмдэг байгаа тохиолдолд хөрөнгийн эргэн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Хөрөнгийн нөхөгдөх үнэ буюу хөрөнгийн ашиг авчрах хэсэг нь түүний ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холдбоотой зардлыг хассан дүнгээс их байна.

Ашиглалтын үнийг тогтоохдоо, хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн орлогыг тухайн хөрөнгийн эрсдэл, зах зээл дээрх мөнгөний үнэ цэнийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн түвшингээр хөнгөлж өнөөгийн үнэ цэнээр тогтооно. Хөрөнгийн үнийн бууралтыг шалгах зорилгоор хөрөнгүүдийг үргэлжилсэн хэрэглээнээс мөнгө бий болгогч хамгийн жижиг нэгжүүдээр бүлэглэх ба эдгээр мөнгө бий болгогч нэгжүүд нь бусад хөрөнгө болон бүлэг хөрөнгийн мөнгөн урсгалаас бүрэн хараат бус байна. Үнийн бууралтыг шалгах зорилгоор, бизнесийн нэгдэл дунд олж авсан гүүдвилийг хамтын ажиллагааны үр өгөөж гэж үзэн мөнгө үүсгэх нэгжид хувиарладаг.

Хөрөнгийн дансны үнэ эсвэл хөрөнгийн ашиг авчрах хэсэг нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрч, орлогын тайланд тусгадаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Гэхдээ хөрөнгийг дахин үнэлсэн дүнгээр тусгасан болон түүнд байгуулсан дахин үнэлгээний илүүдлээс үнийн бууралтын алдагдлын дүн хэтрээгүй байвал үнийн бууралтын алдагдлыг тусгадаггүй. Үнийн бууралтын алдагдлыг эхлээд мөнгө үүсгэх нэгжүүдэд хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг багасгаж, дараа нь нэгж дэх бусад хөрөнгийн дансны үнийг хувь тэнцүүгээр бууруулах замаар бүртгэдэг.

Гүүдвилтэй холбоотой үнийн бууралтын алдагдлыг хүчингүй болгодоггүй. Бусад хөрөнгүүдийн хувьд өмнөх жилүүдэд үүссэн үнийн бууралтын алдагдлыг бууруулах эсвэл байхгүй болтол нь тайлант үе болгоноор үнэлдэг. Нөхөгдөх хэмжээг тодорхойлоход хэрэглэсэн тооцоонд өөрчлөлт гарсан үед үнийн бууралтаас үүсэх алдагдлыг хүчингүй болгодог. Хэрэв үнийн бууралтын алдагдал гараагүй үед хөрөнгийн тодорхойлсон дансны үнэ, элэгдэл, хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс хэтрэхээргүй байхаар үнийн бууралтыг буцааж хүчингүй болгодог.

з) Худалдааны болон бусад өглөг

Худалдааны болон бусад өглөгийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

и) Хувьцаат капитал

Энгийн хувьцаа: -г эзэмшигчдийн өмчид ангилдаг. Энгийн хувьцаа ба хувьцааны опционыг гаргахад шууд хувиардагдах нэмэгдэл өртгийг аливаа татварын нөлөөг хассан цэвэр дүнгээр нь өмчийг бууруулан хүлээн зөвшөөрнө.

й) Ногдол ашиг

Ногдол ашгийг зарласан тухайн тайлангийн хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

к) Орлого хүлээн зөвшөөрөлт

1. Борлуулсан хөрөнгө

Борлуулсан үл хөдлөх хөрөнгө (ҮХХ) –өөс олсон орлогыг буцаалт, худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг хассан цэвэр дүнгээр хүлээн авсан эсвэл хүлээн авах бодит үнэ цэнээр хэмждэг. Дараах нөхцлүүд хангагдсан тохиолдолд борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

- Тухайн ҮХХ-ийн өмчлөлийн голлох эрсдэл болон өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн
- Борлуулсан ҮХХ-ийн удирдлага болон хяналтын аль аль нь компанид үлдээгүй
- Хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ нь хэмжиж болохоор байх
- Ажил гүйлгээний урсгал нь компанид эдийн засгийн өгөөж өгөх магадлалтай байх
- Ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарах өртөг, буцаалтын тооцооллыг найдвартай хэмжих боломжтой байх

2. Үзүүлсэн үйлчилгээ

Үйлчилгээ үзүүлсэн тухайн үед нь үйлчилгээний орлогыг хүлээн зөвшөөрдөг. Үйлчилгээг хэрэглэгчдэд үзүүлээгүй үед хүлээн авсан орлогыг хойшлуулсан орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

3. Түрээсийн орлого

Түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

л) Өртөг/Зардал хүлээн зөвшөөрөлт

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчдэд хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөрийг ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг.

1. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Борлуулалтын өртгийг бараа материалыг борлуулах үед буюу бараа, бүтээгдэхүүний өмчлөлийн эрхийг бусдад шилжүүлж орлого олсон тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг.

2. Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардал

Борлуулалт ба ерөнхий үйл ажиллагааны зардлыг мөнгөөр төлөгдсөнөөс нь үл хамаарч гарсан тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

м) Санхүүгийн орлого/зардал

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтад бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

н) Зээлийн өртөг

Барьж босгоход хугацаа шаардлагатай хөрөнгийн өртөгт багтаж байгаа зээлийн өртгийг тухайн хөрөнгийг ашиглахад бэлтгэх юмуу борлуулах үйл явцад шаардагдах зардал, зээлийн өртөг нь бий болсон үеэс эхлэн капиталжуулдаг.

Бэлтгэл ажил шаардагдах хөрөнгийг худалдан авах, барих, үйлдвэрлэлтэй шууд холбоотой гарсан зээлийн зардлыг (зээлийн хүүг агуулсан) тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулдаг. Харин энэхүү зээлийн өртгийн капиталжуулалтыг тухайн хөрөнгийг барьж босгох үйл явц зогссон юмуу бүрэн дууссан үед зогсоодог.

о) Ажиллагсдын тэтгэмж

1. Түр хугацааны ажиллагсдын тэтгэмж

Богино хугацаат ажиллагсдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажиллагсдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажиллагсдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

2. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 сарын 31 -ний өдрөөр тасалбар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

4. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

<i>(төгрөгөөр)</i>				
№	Үзүүлэлт	Тээврийн хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/				
1.1	2019/01/01 –ний үлдэгдэл		45,300	45,300.00
1.2	Нэмэгдсэн дүн	0.00	0.00	0.00
1.3	Хасагдсан дүн (-)	0.00	0.00	0.00
1.4	Үндсэн хөрөнгө дахин ангилсан			0.00
1.5	Үндсэн хөрөнгө, ХОЗҮХХ хооронд дахин ангилсан			0.00
1.6	2019/12/31 –ний үлдэгдэл	0.00	45,300.00	45,300.00
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ				
2.1	2019/01/01 –ний үлдэгдэл			0.00
2.2	Нэмэгдсэн дүн	0.00	0.00	0.00
2.3	Хасагдсан дүн	0.00	0.00	0.00
2.4	2019/12/31 –ний үлдэгдэл	0.00	0.00	0.00
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН				
3.1	2019/01/01 –ний үлдэгдэл	0.00	45,300.00	45,300.00
3.2	2019/12/31 –ний үлдэгдэл	0.00	45,300.00	45,300.00

5. ДАНСНЫ ӨГЛӨГ

<i>(төгрөгөөр)</i>				
№	Үзүүлэлт	2019/01/01 –ний үлдэгдэл	2019/12/31 –ний үлдэгдэл	
1	Монголын хөрөнгийн бирж ТӨХК -ийн гишүүний хураамж	3,897,912.00	6,397,912.00	
2	ҮЦТХТ ХХК Хадгаламжийн үйлчилгээний хөлс	0.00	600,000.00	
3	Хувь хүнд өгөх өглөг, Б.Батхүү	3,806,973.40	3,806,973.40	
Нийт дүн		7,704,885.40	10,804,885.40	

6. ЭЗДИЙН ӨМЧ

<i>(төгрөгөөр)</i>						
№	Үзүүлэлт	Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа		Давуу эрхтэй хувьцаа		Өмчийн дүн (төгрөгөөр)
		Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	
1	2019/01/01 –ний үлдэгдэл	36,195	3,619,500.00			3,619,500.00
2	Нэмэгдсэн					0.00
3	Хасагдсан (-)					0.00
2019/12/31 –ний үлдэгдэл		36,195	3,619,500.00	0	0.00	3,619,500.00

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 12 сарын 31 -ний өдрөөр тасалбар болсон жилийн

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

7. ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН (АЛДАГДАЛ)

(төгрөгөөр)			
№	Үзүүлэлт	2019/01/01 –ний үлдэгдэл	2019/12/31 –ний үлдэгдэл
1	Тайлант оны эхний үлдэгдэл	(11,279,085.40)	(11,279,085.40)
2	Өмнөх тайлант үеийн зардалд хамаарах төлбөрийг төлсөн	0.00	0.00
3	Тайлант үеийн ашиг	(6,000.00)	(3,100,000.00)
Нийт алдагдлын дүн		(11,279,085.40)	(14,379,085.40)

8. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(төгрөгөөр)			
№	Үзүүлэлт	Ерөнхий удирдлагын	
		Өмнөх онд	Тайлант онд
1	Монголын хөрөнгийн бирж ТӨХК -ийн гишүүний хураамж		2,500,000.00
2	ҮЦТХТ ХХК Хадгаламжийн үйлчилгээний хөлс		600,000.00
Нийт дүн		0.00	3,100,000.00

9. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

№	Холбоотой талын нэр	Холбоо хамаарал	Эзэмшлийн хувь
1	“Экспонэйшл фанд менежмент ҮЦК” ХХК /Хөрөнгө оруулалтын менежментийн/	Хамгийн дээд хяналт тавигч, хувьцаа эзэмшигч	41.0 %
2	Б.Батхүү	Толгой компанийн Гүйцэтгэх захирал	